

**БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Байгууллагын 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн нийт 14 чиглэлийн хүрээнд 82 ажлыг төлөвлөн ажилласан.

НЭГ.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2022 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД:

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилгын II ээлж барих ажлыг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд 12 ажлыг хийж гүйцэтгэсэн.Тайлант хугацаанд нийт санхүүжилт 21,702,900.0 мян.төгрөгөөс 2022 онд санхүүжих дүн 9,200,000.00 мян.төгрөгийн санхүүжилтийг баталгаажуулж 1,700,000.0 мян.төгрөгийг гүйцэтгэгч компаниудад санхүүжилт хийгдсэн Дундаж хэрэгжилт 65 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
1.1	Хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажлын гэрээний дүн 1,550,011.0 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,240,008.8 мян.төгрөг	80 хувь	80 хувь
1.2	Сэлбэг, аж ахуйн агуулахын барилга угсралтын ажлын гэрээний нийт дүн 300,600.4 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 255,510.4 мян. Төгрөг	75 хувь	75 хувь
1.3	Уурын зуухны барилга угсралтын ажлын гэрээний нийт дүн 540,699.5 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 348,544.3 мян төгрөг	70 хувь	70 хувь
1.4	Шатахуун түгээх станцын барилга угсралтын ажлын гэрээний нийт дүн 184,000.0 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 165,600.5 мян. төгрөг	90 хувь	90 хувь
1.5	Тос тосолгооны агуулахын барилгын ажлын гэрээний нийт дүн 311,879.5 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 210,511.0 мян.төгрөг	50 хувь	50 хувь
1.6	Дулаан гараашны барилга угсралтын багц 1 ажлын гэрээний дүн 3,855,451.3 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,604,101.2 мян.төгрөг	60 хувь	60 хувь
1.7	Дулаан гараашны барилга угсралтын багц 2 ажлын гэрээний дүн 3,855,451.3 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 900,000.0 мян төгрөг	45 хувь	45 хувь
1.8	Дулаан гараашны барилга угсралтын багц 1 ажлын гэрээний дүн 3,855,451.3 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,604,101.2 мян.төгрөг	60 хувь	60 хувь
1.9	Ногоон байгууламж, зам талбайн барилгын ажлын гэрээний дүн 1,651,731.6 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 650,000.0 мян.төгрөг	45 хувь	45 хувь
1.10	Автобус паркийн харуулын байр, хашаа, дэд бүтцийн ажлын гэрээний дүн 1,651,731.6 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 650,000.0 мян.төгрөг	90 хувь	90 хувь
1.11	Угаах цех, кузов засварын барилгын ажлын гэрээний дүн 2,274,432.6 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,295,696.7мян. төгрөг	90 хувь	90 хувь

1.12	Цахилгаан хангамжийн ажлын гэрээний нийт дүн 1,246,595.3 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,043,528.9 мян.төгрөг	65 хувь	65 хувь
Хэсгийн дундаж хувь		65 хувь	65 хувь

ХОЁР.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 6.3 “УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙГ ХАНГАСАН, СТАНДАРТАД НИЙЦСЭН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ” ГЭСЭН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

“Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” зорилтыг тавин 2 ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 43,5 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
2.1.	2.1.1.Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан автобусаар нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх	100 хувь	38 хувь
2.1	2.1.2.Парк шинэчлэлт хийхэд зориулсан орон нутгийн зээллэгийн эргэн төлөлтийг тайлант онд үндсэн зээл болон хүүгийн төлбөрт нийт 10,935,841.1 (арван тэрбум есөн зуун гучин таван сая найман зуун дөчин нэгэн мянга нэг зуун арван нэгэн төгрөг хорин таван мөнгө) төгрөг төлсөн.	100%	49%
Хэсгийн дундаж хувь		100 хувь	43,5 хувь

ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 206 ДУГААР ТОГТООЛЫН “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН 2020 ОНЫ 100 ТООТ ТУШААЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах” зорилтыг тавин 13 ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 91,9 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
3.1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтэс, нэгжүүдээс авч нэгтгэн төлөвлөгөөний биелэлтийг удирдлагуудад танилцуулан баталгаажуулна.	100 хувь	100 хувь
3.2	Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн баталгаажуулж, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.	100 хувь	100 хувь
3.3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэх.	100 хувь	100 хувь
3.4	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэх.	100 хувь	100 хувь
3.5	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэх.	100 хувь	80 хувь
3.6	Байгууллагын бие даасан санхүүгийн чадавхыг дээшлүүлэх, зардлын зөрүүг санхүүжүүлэх тариф нэмэгдүүлэх саналыг боловсруулж хүргүүлнэ.	100 хувь	100 хувь
3.7	Байгууллагын 2022 оны төлөвлөгөө, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын төслийг боловсруулж Удирдах зөвлөлд танилцуулан батлуулна.	100 хувь	100 хувь

3.8	Байгууллагын 2021 оны зорилтын биелэлтийг гарган Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газарт хүргүүлэх, байгууллагын даргын контракт гэрээг дүгнүүлнэ.	100 хувь	100 хувь
3.9	Байгууллагын даргын 2022 оны контракт гэрээний төслийг боловсруулж Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газарт хүргүүлэн хянуулж гэрээг байгуулна.	100 хувь	100 хувь
3.10	Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж үндсэн хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа, бараа материалын тооллогыг сар бүр хийж тооллогын үр дүнг даргын зөвлөлд танилцуулна.	100 хувь	100 хувь
3.11	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулж авлага, өр төлбөрийг тогтмол бууруулна.	100 хувь	45 хувь
3.12	2022 онд хийгдэх худалдан авалтын гэрээ байгуулж батлуулах, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компаниудаас үнийн санал авах, харьцуулалт хийх, бараа материал, сэлбэг хэрэгсэл түргэн шуурхай нийлүүлнэ.	100 хувь	80 хувь
3.13	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох гүйлгээ, тайлан мэдээ, тушаал шийдвэрийг стандарт, журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд оруулж байршуулна.	100 хувь	90 хувь
Хэсгийн дундаж хувь		100 хувь	91,9 хувь

ДӨРӨВ:БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 1. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, ШИНЭ МЭДЛЭГ, ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН, ОЛОН НИЙТЭД ТҮШИГЛЭСЭН МЕНЕЖМЕНТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, УЛСЫН ЖИШИГТ ХҮРСЭН БАЙГУУЛЛАГА БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ, ХҮН АМ ХҮРЭЭЛЭН БҮЙ БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

“Дэвшилтэт техник технологи, программ хангамж ашиглан нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийг оновчтой боловсронгуй болгох” зорилтыг тавин 2 ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 94,7 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
4.1	Нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлт, ТВОХ цахим системийн сайжруулалтын талаарх санал хүргүүлнэ.	89,4 хувь	89,4 хувь
4.2	Нийтийн тээврийн үйлчилгээний хөдөлгөөний мэдээлэл, хяналт, зохицуулалтын удирдлагын төв байгуулна.	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж хувь		94,7	94,7

ТАВ:БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

“Иргэдээс ирэх санал гомдол, зам тээврийн осол зөрчил, ашиглалтын саатлыг бууруулж, шугамын үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлж, чанар стандартыг хэрэгжүүлэх” зорилтыг тавин 11 ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дундаж хэрэгжилт 73,9 хувь.

№	Төлөвлөсөн ажил		Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
5.1	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор хамтран ажиллаж буй байгууллагуудтай байгуулсан	Гэрээний үүргийн биелэлтийн хувь	100 хувь	92,7 хувь
5.2		Үйлчилгээний санал гомдлын зөрчлийг бууруулсан тоо	100 хувь	50 хувь
5.3		Шугам замын ашиглалтын саатлыг бууруулсан цаг	50 хувь	30 хувь

5.4	гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.	Зам тээврийн осол зөрчлийг бууруулсан тоо	70 хувь	50 хувь
5.5		MNS:5012:2011 стандартын хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь
5.6	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2021 стандартын шаардлага хангуулах	Хяналт, шалгалтын тоо	100 хувь	100 хувь
5.7		Цэвэрлэгээ, үйлчилгээ хийсэн ажлын чанарын үзүүлэлт, хувь	100 хувь	100 хувь
5.8	Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2021		90 хувь	90 хувь
5.9	Ажлын байрны орчин нөхцөл, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах	Ажлын байрны нөхцөл сайжруулан, худалдан авсан тоног төхөөрөмж, сая төгрөг	50 хувь	50 хувь
5.10		Эцсийн буудлуудад хоолны газар, бие засах газар байгуулах санал хүргүүлсэн тоо	70 хувь	70 хувь
5.11	Үйлчилгээний соёл, зан харилцааны доголдолгүй ажиллах		80 хувь	80 хувь
Хэсгийн дундаж хувь			82,7 хувь	73,9 хувь

ЗУРГАА:БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.2-ЫН ХҮРЭЭНД:

"Нийт хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар үйлчилгээний технологийг мөрдөх, засвар үйлчилгээний ажлыг шуурхай оновчтой зохион байгуулах" зорилтыг тавин 7 ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дундаж хэрэгжилт 70,8% хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
6.1	Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг улсын үзлэг, оношилгоонд бэлтгэл ажлыг хангаж бүрэн хамруулах	100 хувь	100 хувь
6.2	Засвар үйлчилгээнд хамрагдсан хөдлөх бүрэлдэхүүний техникийн ерөнхий байдалд тогтмол хяналт тавьж, Техникийн бэлэн байдлын коэффициентийг байнга дээшлүүлэн 85%-д хүргэж ажиллах	65,4 хувь	65,4 хувь
6.3	Техникийн саатлыг 2021 оныхоос бууруулах техник зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	30 хувь	30 хувь
6.4	Цахидгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах	100 хувь	100 хувь
6.5	Засвар үйлчилгээний засварчдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны багаж хэрэгслийн үзлэг, шалгалтыг сар бүр хийж дутуу болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон хамгаалах хэрэгслийг солих нөхөн хангалт хийх ажлыг зохион байгуулах	100 хувь	100 хувь
6.6	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээ хийлгэх.	0 хувь	0 хувь
6.7	Хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавих, үзлэг, шалгалт хийх, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, чанаржуулах ажлыг зохион байгуулна.	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж хувь		70,8 хувь	70,8 хувь

ДОЛОО:СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.2-ЫН ХҮРЭЭНД:

"Байгууллагын барилга байгууламж, дулаан болон ил зогсоол, зам талбайн бүрэн бүтэн байдлыг хангах, цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбоо зэрэг инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангаж ажиллах" зорилтыг тавин 3 ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 96.6 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
7.1	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын болон хамгаалах хэрэгслээр хангаж, түүнийг байнгын хэрэглээнд хэвшүүлэх	100 хувь	100 хувь
7.2	Хөдөлмөр хамгаалал, орчны аюулгүй ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, галын аюулгүй ажиллагааг ханган, урьдчилан сэргийлж ажиллах	100 хувь	100 хувь
7.3	Дүүргийн онцгой байдлын хэлтэс, гал унтраах ангиудтай хамтран, Гамшиг ослоос урьдчилсан сэргийлэх дадлага сургалт зохион байгуулах	90 хувь	90 хувь
Хэсгийн дундаж хувь		96,6 хувь	96,6 хувь

НАЙМ: "ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

“Ажлын байрны орчин, эрүүл ахуйг сайжруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, ажилтнуудын ажиллах нөхцөлийг хангах, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах” зорилтыг тавин 5 ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 98 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
8.1	Ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үр дүнг тооцон, ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгч ажиллана.	100 хувь	100 хувь
8.2	Ажилтан, албан хаагчдын ажлыг үр дүнгээр тооцож, урамшууллыг тогтмол олгоно.	100 хувь	100 хувь
8.3	Үйлдвэрчний эвлэлийн хорооны хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	100 хувь	100 хувь
8.4	Хүний хөгжлийн бодлогыг баримтлан байгууллагын ажилтан, албан хаагчдын эрүүл мэнд, биеийн тамир, уралдаан тэмцээн, соёл урлагийн ажлыг зохион байгуулах.	100 хувь	90 хувь
8.5	Байгууллагын ахмад болон ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж хувь		100 хувь	98 хувь

ЕС: СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.4-ИЙН ХҮРЭЭНД:

“Удирдах ажилтны удирдах арга барил, менежмент, сургалт, сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох” зорилтыг тавин 6 ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 98,3 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
9.1	“Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллаж, байгууллагын Ёс зүйн хороог байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын вэб сайтад байршуулна.	100 хувь	100 хувь

9.2	Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн мэдээ, байгууллагын ХАСХОМ-ийн мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын судалгааг гаргаж НЗТГ-т хүргүүлэх	100 хувь	100 хувь
9.3	Албан тушаалын сул орон тоог хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сонгон шалгаруулах зарчмаар уг орон тоог нөхнө.	100 хувь	90 хувь
9.4	Байгууллага сурталчлах ажлыг зохион байгуулах, сонин хэвлэл, телевиз, пейж хуудас, мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлах	100 хувь	100 хувь
9.5	Ажилтан, албан хаагчдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	100 хувь	100 хувь
9.6	Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт, нэгдсэн системийн ашиглалтын талаар албан хаагчдад сургалт зохион байгуулах	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж хувь		100 хувь	98,3 хувь

АРАВ:СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.5-ЫН ХҮРЭЭНД:

“Сахилга дэг журам, ажлын хариуцлагыг сайжруулах, хууль, тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг хангах, дүрэм журмыг боловсронгуй болгох, ёс зүйн үйл ажиллагааг тогтмолжуулах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх” зорилтыг тавин 8 ажлыг хийж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 98,6 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
10.1	УИХ, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн ИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, дээд газрын үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах	99,5 хувь	99,5 хувь
10.2	Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 тоот “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжилтийг хангана.	100 хувь	100 хувь
10.3	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангана.	100 хувь	100 хувь
10.4	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангана.	100 хувь	100 хувь
10.5	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай” 33 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах	100 хувь	100 хувь
10.6	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	100 хувь	100 хувь
10.7	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	100 хувь	90 хувь
10.8	Албан хаагчдын албан тушаалын чиг үүргийн хуваарилалт, ажлын давхардал байгаа эсэхэд хяналт, шинжилгээ хийж албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулна.	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж хувь		99,9 хувь	98,6 хувь

АРВАН НЭГ:БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.6-ЫН ХҮРЭЭНД:

Бусад ажлын хүрээнд 7 ажил төлөвлөж гүйцэтгэсэн.

Дундаж хэрэгжилт 95,7 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт- шинжилгээ, үнэлгээ
11.1	Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд мод тарих, цэцэрлэгжүүлэх, талбайн бүх нийтийн цэвэрлэгээ зэрэг нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах, ажилтан, албан хаагчдыг оролцуулах	100 хувь	100 хувь
11.2	"Шарилжгүй Улаанбаатар" аяны хүрээнд байгууллагын ногоон байгууламжийн хог шарилжийг цэвэрлэх	100 хувь	100 хувь
11.3	Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажиллах	100 хувь	100 хувь
11.4	Хүүхдийн эрхийн тухай хууль, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн дагуу байгууллагын дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл" байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	100 хувь	90 хувь
11.5	Ахмад, залуу үеийн холбоог сайжруулах, ахмадуудаас суралцах, ажлын дадлага туршлагыг нь өвлүүлэх, халамжлан хүмүүжүүлэх зорилгоор ахмад, залуу үеийн уулзалтыг зохион байгуулж ажиллана.	100 хувь	100 хувь
11.6	Нийгмийн харилцааны талаар сэтгэл зүйн ажлыг зохион байгуулах	80 хувь	80 хувь
11.7	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврын дагуу байгууллагын цахим хуудсыг англи хэл дээр танилцуулдаг болгох.	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж		97,1	95,7%

АРВАН ХОЁР:БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.7-ЫН ХҮРЭЭНД:

"Ковид-19" цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд 2 ажил төлөвлөж гүйцэтгэсэн.

Дундаж хэрэгжилт 100 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт- шинжилгээ, үнэлгээ
12.1	Цаг үеийн байдалтай холбогдуулан "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж ажиллах.	100 хувь	100 хувь
12.2	Ариутгал, халдваргүйтгэл хийх, бодисын нөөц бүрдүүлэх, байгууллагын эзэмшлийн зам талбай, объектуудад, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулж ажиллах.	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж хувь		100 хувь	100 хувь

АРВАН ГУРАВ:БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5-ЫН ХҮРЭЭНД:

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын хүрээнд 3 ажил төлөвлөж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 100 хувь.

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
13.1	Батлагдсан төлөвлөгөөний дагуу нээлттэй тендер зарлах, тендерийн бичиг баримт боловсруулах, үнэлгээний хороо байгуулж сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу зохион байгуулна.	100 хувь	100 хувь
13.2	Байгууллагын хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдлыг хангах Нээлттэй ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайтад зарлаж, сонгон шалгаруулалт хийх.	100 хувь	100 хувь
13.3	Нийслэл, харьяа дүүргээс зохион байгуулагддаг ажлын байр сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож нээлттэй ажлын байрыг иргэдэд танилцуулах, иргэдийг байнгын ажлын байранд бүртгэх, хүний нөөцийн бүрдүүлэлт хийх, ажлыг зохион байгуулах	100 хувь	100 хувь
Хэсгийн дундаж хувь		100 хувь	100 хувь

АРВАН ДӨРӨВ:БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 6-ЫН ХҮРЭЭНД:

Дотоод хяналт, шалгалтын чиглэлийн хүрээнд 1 ажил төлөвлөж гүйцэтгэсэн. Дундаж хэрэгжилт 100 хувь

№	Төлөвлөсөн ажил	Ажлын Гүйцэтгэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
14.1	Байгууллагын нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон хөндлөнгийн байгууллагаар судалгаа шинжилгээ, хяналт, шалгалтыг хийж, зөвлөмж хүргүүлэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	100 хувь	100 хувь

Дүгнэлт:Нийт 14 зорилт, 82 үйл ажиллагаа төлөвлөгдөн, 2022 оны жилийн эцсийн байдлаар 87,6 хувьтай хэрэгжсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,1 хувиар өссөн үзүүлэлттэй.

Байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд 2022 онд төлөвлөгөөнд тусгагдсан нийт 14 зорилт, 82 ажил хийж гүйцэтгэснээс 45 ажил нь "Үр дүнтэй" буюу 100 хувийн үнэлгээтэй, 21 ажил нь "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70-99 хувийн үнэлгээтэй, 15 ажил нь "Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 30-69 хувийн үнэлгээтэй, 1 ажил нь "Үр дүнгүй" буюу 0-29 хувийн үнэлгээтэй, нэгдсэн дүнгээр 87,6 хувийн үнэлгээгээр "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

2022 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийг 2021-2024 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилт, 2 арга хэмжээ нь "Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 43,5 хувийн биелэлттэй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилт, 12 арга хэмжээ нь

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 65 хувийн биелэлттэй, нэгдсэн дүнгээр 54,2 хувийн үнэлгээгээр “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн.

№	Бодлогын баримт бичиг	Хувь
Зорилго 1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр		
1.1	Хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажил	80 хувь
1.2	Сэлбэг, аж ахуйн агуулахын барилга угсралтын ажил	75 хувь
1.3	Уурын зуухны барилга угсралтын ажил	70 хувь
1.4	Шатахуун түгээх станцын барилга угсралтын ажил	90 хувь
1.5	Тос тосолгооны агуулахын барилгын ажил	50 хувь
1.6	Дулаан гараашны барилга угсралтын багц 1 ажил	60 хувь
1.7	Дулаан гараашны барилга угсралтын багц 2 ажил	45 хувь
1.8	Дулаан гараашны барилга угсралтын багц 1 ажил	60 хувь
1.9	Ногоон байгууламж, зам талбайн барилгын ажил	45 хувь
1.10	Автобус паркийн харуулын байр, хашаа, дэд бүтцийн ажил	90 хувь
1.11	Угаах цех, кузов засварын барилгын ажил	90 хувь
1.12	Цахилгаан хангамжийн ажил	65 хувь
Хэсгийн дундаж 65 хувь		
Зорилго 2. Нийслэлийг 2021-2024 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		
2.1.	2.1.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан автобусаар нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх	38 хувь
	2.1.2. Парк шинэчлэлт хийхэд зориулсан орон нутгийн зээллэгийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөх	49 хувь
Хэсгийн дундаж 43,5 хувь		
Нийт дундаж 54,2 хувь		

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоол, Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар хавсралтыг үндэслэн 2022 оны жилийн эцсийн байдлаар 36 тогтоол шийдвэрийн 44 заалтыг хяналтад авч хэрэгжүүлсэн.

Монгол Улсын хуулийн 9, Ерөнхийлөгчийн зарлиг 1, Ерөнхий сайдын албан даалгавар-1, Засгийн газрын тогтоол 6, Нийслэлийн Засаг даргын 14 захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр 5 шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан.

Нийт 36 шийдвэрийн 44 заалтаас 90-100 хувь буюу бүрэн хэрэгжсэн биелэлттэй 43 шийдвэр, хэрэгжилтийн шатанд явж байгаа 50-89 хувьтай 1 шийдвэр, ерөнхий дунджаар 99,5 хувьтай буюу “Бүрэн хэрэгжсэн” гэж дүгнэсэн.

№	Баримт бичгийн нэр	Хувь
1. Монгол улсын хууль		
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	100%
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль	100%
3	Хөдөлмөрийн тухай хууль	100%
4	Төрийн хэмнэлтийн тухай хууль	98,8%
5	Автотээврийн тухай хууль	100%
6	Жолоочийн даатгалын тухай	100%
7	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	100%
8	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	95,7%

9	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	100%
Хэсгийн дундаж 99,5 хувь		
2 Ерөнхийлөгчийн зарлиг		
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" /Тэрбум мод/ №58 дугаар зарлиг	100 хувь
Хэсгийн дундаж 100 хувь		
3. Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар		
	Дугаар 06 Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн сурталчлан таниулах тухай	100 хувь
4. Засгийн газрын тогтоол		
1	Монгол улсын Засгийн газрын 2011 оны тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах нийтлэг журмыг батлах тухай" №311 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан.	100 хувь
2	Монгол улсын Засгийн газрын 2018 оны тогтоол "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" №43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан.	100 хувь
3	Дугаар 1 Коронавируст халдвар (Ковид19)-ын цар тархалтын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай	90 хувь
4	Дугаар 201 "Журам батлах тухай"	98 хувь
5	Дугаар 203 "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"	100 хувь
6	Дугаар 64 "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай"	100 хувь
Хэсгийн дундаж 99 хувь		
5. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол		
1	Дугаар 41 "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын нийгмийн даатгалын өрийг шийдвэрлэх тухай"	100 хувь
2	Дугаар 79 Машин цагийн зардлын тарифыг шинэчлэн батлах тухай	100 хувь
Хэсгийн дундаж 100 хувь		
6 Нийслэлийн Засаг даргын захирамж		
1	Дугаар А/01 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарлах тухай"	100 хувь
2	Дугаар А/44 Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай	100 хувь
3	Дугаар А/54 "Улаанбаатар Марафон" олон улсын гүйлт зохион байгуулах тухай	100 хувь
4	Дугаар А/578 "Ажлын хэсэг байгуулах тухай"	100 хувь
5	Дугаар А/598 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2021 оны ажлыг дүгнэх тухай"	100 хувь
6	Дугаар А/768 "Нийслэл хотын ялгамж чанарыг илтгэх тэмдгийг батлах тухай"	100 хувь
7	Дугаар А/789 "Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай"	100 хувь
8	Дугаар А/851 "Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай"	100 хувь
9	Дугаар А/912 "Нэг тархи-Нэгдсэн систем" төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах тухай	100 хувь
10	Дугаар А/917 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын нийгмийн даатгалын өрийг шийдвэрлэх тухай	100 хувь
11	Дугаар А/1038 Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай	100 хувь
12	Дугаар А/1106 Журам шинэчлэн батлах тухай	100 хувь

13	Дугаар А/1206 "Автомашингүй өдөр" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай	100 хувь
14	Дугаар А/1224 Машин цагийн зардлын задаргааг шинэчлэн батлах тухай	100 хувь
Хэсгийн дундаж хувь 100%		
7.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар		
1	Дугаар 01"Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны жилийн эцсийн тайлан.	100 хувь
2	Дугаар 11 "Хотын иргэний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийн явц	100 хувь
3	Дугаар 16 Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2022 оны 3-р улирлын тайлан.	100 хувь
4	Дугаар 17 Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай А/851 дугаар захирамжийн биелэлт	100 хувь
5	Дугаар 20 "Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц	100 хувь
Хэсгийн дундаж 100 хувь		
Нийт дундаж 99,5 хувь		

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 374 дугаар тогтоол, Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 9 дүгээр хавсралтыг үндэслэн нийт 5 шалгуурын 36 үзүүлэлтийн ажлыг төлөвлөн ажилласан.

Дундаж хэрэгжилт 89.9 хувь.

№	Шалгуур үзүүлэлт	Хувь
Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.		
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн.	100 хувь
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг.	100 хувь
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж.	100 хувь
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан.	99,5 хувь
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан.	54,2 хувь
1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт.	100 хувь
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг.	100 хувь
1.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ.	100 хувь
1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл.	87 хувь

1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	100 хувь
Хэсгийн дундаж 94% хувь		
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал.		
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл.	100 хувь
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам.	100 хувь
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм.	100 хувь
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам.	90 хувь
2.5.	Хүний нөөцийн удирдлага ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.	100 хувь
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	80%хувь
Хэсгийн дундаж 95 хувь		
Гурав.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.		
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл.	100 хувь
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан.	100 хувь
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.	100 хувь
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ.	100 хувь
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар.	100 хувь
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг.	100 хувь
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт.	100 хувь
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр.	100 хувь
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл.	100 хувь
3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт, шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан.	80 хувь
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт.	100 хувь
3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл.	100 хувь
3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн.	40 хувь
Хэсгийн дундаж 93,8 хувь		
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.		
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл.	100 хувь

4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	100 хувь
Хэсгийн дундаж 100 хувь		
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал.		
5.1.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл.	70 хувь
5.2.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл.	100 хувь
5.3.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл.	100 хувь
5.4.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл.	38,5 хувь
5.5.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт.	100 хувь
Хэсгийн дундаж 81,7 хувь		
Нийт дундаж 92,9 хувь		

ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЖИЛТЭЭС ХАРАХАД:

Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын шинэ автобус баазын барилгын 2 дугаар ээлжийн ажлыг эхлүүлснээр байгууллагын ажлын байрны нөхцөл сайжрах, засвар үйлчилгээний чанар хүртээмж дээшлэх, тээврийн хэрэгслийн болон сэлбэг материалын хадгалалт, хамгаалалтын стандарт шаардлагыг бүрэн хангасан барилга байгууламжтай болно.

Нийтийн тээврийн үйлчилгээнд стандарт шаардлага хангасан тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд холбогдох ажлын хэсэгт байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч нар орон техникийн болон эдийн засгийн тооцоо судалгааг гарган дээд шатны байгууллагад танилцуулж, 2022 оны 06 дугаар сард их багтаамжийн тусгай тоноглолтой, 100% цахилгаан 2 давхар 10 автобус, дан цахилгаан 1 автобус нийт 11 автобус хүлээн авч, ирэх онд их багтаамжийн 110 автобусаар парк шинэчлэлт хийх зорилт тавин ажиллаж байна.

Нийслэлийг 2021-2024 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг байгууллагын түвшинд холбогдох санал, судалгааг өгч хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч бусад дээд шатны байгууллагуудаас шалтгаалан ажил удааширсан, төсөв хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, бодлогын түвшинд зохицуулалт хийх шаардлагатай байна. Тухайлбал Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийх, цахилгаан автобус цэнэглэх цэг байгуулах, нийтийн тээврийн эцсийн зогсоолыг сайжруулах зэрэг ажлуудын шийдвэр гаралт удаашралтай.

Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгэх гэрээний дагуу үйлчилгээний гомдол, зам тээврийн осол зөрчил, техникийн саатал, ашиглалтын саатлыг бууруулж ажиллах ажлын хэрэгжилт хангалтгүй байгаа нь 2009, 2015 онд үйлдвэрлэгдэж шугамын үйлчилгээнд ажилласан их багтаамжийн болон дунд оврын автобусны насжилт дуусаж, сэлбэг материалын олдоц ховордсон. Нийтийн тээврийн мэргэшсэн туршлагатай жолооч нарын дутагдалд орсон зэрэг шалтгаалсан гэж үзэж байна.

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.ОТГОНБААТАР



НЭГТГЭЖ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ АЖИЛТАН Л.ТУЛГА